



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**ЕРӨӨ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ТӨМӨРБААТАРЫН УУГАНБАЯР ТАНАА**

2024.09.03 № ГНАГ-2024/13-УСТА-НБ-101

танай _____-ны № _____-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч Төмөрбаатарын Ууганбаярын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн

018721090

төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Төмөрбаатарын Ууганбаяр /ТА95050555/-ын Ерөө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Төмөрбаатарын Ууганбаярын мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Ерөө сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЕРӨӨ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ТӨМӨРБААТАРЫН УУГАНБАЯРЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

- 
1. Сурагчдын хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш боловсон хүчин, хүний нөөцийг бэхжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.
 2. Сурагчдад эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжлийн талаар бодит мэдээллийг хүргэх замаар орон нутгийг боловсон хүчээр хангах бодлогыг дэмжиж ажиллана.
 3. Дотуур байрны сурагчдын өсөлтийн тоонд тулгуурлан шаардлага хангасан дотуур байртай болох ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
 4. Иргэдэд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгооны хамрагдалтыг нэмэгдүүлэх бодлогыг дэмжинэ.
 5. Иргэдийн дунд зонхилон тохиолдож буй илүүдэл жинг бууруулах зорилгоор нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх санал санаачилга гаргасан иргэн, аж ахуйн нэгжийг дэмжин ажиллана.
 6. Эрүүл мэндийн төвийг нарийн мэргэжлийн эмчээр хангаж, тэдний ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, урт хугацааны гэрээ байгуулж тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана.
 7. Төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоо, идэвх санаачилгыг дэмжин “Эрүүл, идэвхтэй амьдрал” хөтөлбөр боловсруулан спортын дасгал хөдөлгөөн, иог, нийтийн болон цэнгээнт бүжгээр хичээллэж эрүүл, зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэн, эерэг хандлагатай иргэн болж төлөвших нөлөөллийн үйл ажиллагааг дэмжинэ.
 8. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, иргэдэд сурталчлан таниулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулан ажиллана.
 9. Улс болон дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцож сум орон нутгийнхаа нэр хүндийг өндөрт өргөж яваа иргэдийг дэмжин ажиллана.
 10. Сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гудамж талбайн тохижилтыг сайжруулах санал санаачилга дэвшүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг бүх талаар дэмжих бодлого боловсруулан ажиллана.
 11. Чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулж, амьдруулах зорилгоор ХАУС хороолол барих иргэн, аж ахуйн нэгжийг бодлогоор дэмжин хамтран ажиллана.
 12. Тэрбум модны хүрээнд өрх бүрийг жимс, жимгэсний модоор хангах ажлыг зохион байгуулна.
 13. Сумын хэмжээнд “Мөсөн сур”-ын харвааг хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.
 14. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа болон шинээр эрхлэх иргэн, аж ахуй нэгж байгууллагыг дэмжинэ.
 15. Үйлдвэр үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн аж ахуйн нэгжийг дэмжин, санал санаачилгыг холбогдох байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлнэ.
 16. Эрчимжсэн мал аж ахуй болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжин ажиллана.